

**ХӨДӨЛМӨРИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫН БОЛОН  
ДАГАЛДАЖ ӨРГӨН МЭДҮҮЛСЭН БУСАД ХУУЛИЙН ТӨСЛИЙГ ХЭЛЭЛЦЭХ ЭСЭХ  
ТАЛААР НИЙГМИЙН БОДЛОГО, БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ  
БАЙНГЫН ХОРООНООС ГАРГАСАН САНАЛ, ДҮГНЭЛТ**

2015 оны 06 дугаар  
сарын 23-ны өдөр

Улаанбаатар  
хот

**Илтгэгч нь: Улсын Их Хурлын гишүүн  
А.Тлейхан**

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ

Монгол Улсын Засгийн газраас Улсын Их Хуралд 2015 оны 06 дугаар сарын 15-ны өдөр өргөн мэдүүлсэн Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын болон дагалдаж өргөн мэдүүлсэн бусад хуулийн төслийг хэлэлцэх эсэх асуудлыг тус Байнгын хороо 2015 оны 06 дугаар сарын 23-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Хуулийн төсөлд хөдөлмөрийн харилцааны хамрах хүрээг өргөтгөх, хөдөлмөрийн хүрээний суурь зарчим, хамтын гэрээ, хэлэлцээр байгуулах эрхийг хангах, хөдөлмөрийн харилцаа үүсэх, өөрчлөгдөх, дуусгавар болох, хөдөлмөрийн маргааныг хэрхэн шийдвэрлэх тухай, хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэр, хөдөлмөрийн харилцаанд ялгavarлан гадуурхахыг хориглох тухай болон хөдөлмөрийн гэрээ, хөдөлмөрийн зах зээлд бий болсон эрх зүйн шинэ харилцааг зохицуулах зэрэг асуудлыг тусгасан байна.

Хуулийн төсөл батлагдсанаар иргэдийн хөдөлмөрлөх суурь эрх хангагдах, бүрэн бус цагаар ажиллах, зайнаас ажиллах үеийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, гэрийн үйлчилгээний, хөлсөөр мал маллаж буй ажилтан болон оюутны хөдөлмөр эрхлэлтийн харилцааг зохицуулах, хөдөлмөрийн харилцааны хөгжлийн чиг хандлагатай уялдуулан хуулийн зохицуулалтын үр нөлөөг дээшлүүлэх, хамрах хүрээг өргөжүүлэх ач холбогдолтой болно.

Хуулийн төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн А.Тлейхан монгол хүний хөдөлмөрийн үнэлэмжийг дээшлүүлэх, цалин хөлсний зохицуулалтыг боловсронгуй болгох, Улсын Их Хурлын гишүүн Ц.Оюунгэрэл ээжүүдийг хүүхэд асрах чөлөөтэй байх хугацаанд ажил олгогч нийгмийн даатгалын шимтгэлийг төлөх нь эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлт болон хүн амын төрөлтөнд хэрхэн нөлөөлөх, бэлгийн цөөнх иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих талаар ямар арга хэмжээ хэрэгжүүлж байгаа тухай хууль санаачлагчаас асуулт асууж, хариулт авлаа.

Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх нь хуулийн төслүүдийг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэж үзлээ.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ.

Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулга болон Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн

даатгалын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Төрийн албаны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эвлэрүүлэн зуучлалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хууль хүчингүй болсонд тооцох тухай зэрэг хуулийн төслийг хэлэлцэх эсэх талаар Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

НИЙГМИЙН БОДЛОГО, БОЛОВСРОЛ,  
СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ БАЙНГЫН  
ХОРООНЫ ДАРГА

Д.БАТЦОГТ

